



**“МОНГОЛ ШУУДАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2017 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 17/05

Улаанбаатар хот

Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэхь заалт, “Монгол шуудан” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2017 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол шуудан” хувьцаат компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар “Хангалттай” гэж дүгнэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрч баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.НАРАНГЭРЭЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны
зардлын төсөв батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, “Монгол шуудан” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2017 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол шуудан” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны зардлын төсвийг хавсралтын дагуу нийт 100,250,000.00 /Нэг зуун сая хоёр зуун тавин мянга/ төгрөгөөр баталсугай.

2. Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо /Д.Дэлгэрмаа/-нд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.НАРАНГЭРЭЛ

“Монгол шуудан” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн
 ээлжит хурлын 2017 оны 04 дүгээр сарын 26-ны
 өдрийн 119 дугаар тогтоолын хавсралт



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
 2017 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

д/д	Зардлын төрөл	Тоо	Нэгж зардал /мян.төг/	Давтамж	Нийт дүн /мян.төг/
1. Цалингийн зардал					
1	ТУЗ-ийн цалин /ЭМ/НДШ/ 2017 оны 1-3 сарын гүйцэтгэл	9		3	15450.0
2	ТУЗ-ийн дарга	1	800.0	9	7200.0
3	ТУЗ-ийн дэргэдэх хорооны дарга	3	750.0	9	20250.0
4	ТУЗ-ийн гишүүд	5	700.0	9	31500.0
5	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	1	700.0	9	6300.0
6	Нийгмийн даатгалын шимтгэл	9		9	7050.0
	дүн				87750.0
2. Бичиг хэрэг, зохион байгуулалтын зардал					
1	Бичиг хэрэг, хангамжийн зардал		125.0	12	1500.0
2	Шатахуун				1000.0
3	Зохион байгуулалтын үйл ажиллагааны зардал				10000.0
	дүн				12500.0
	НИЙТ ДҮН				100250.0